

UCS 1604B:2022

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




Хүүхдийн автобусанд тавих ерөнхий шаардлага

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Хүүхдийн автобусанд тавих ерөнхий шаардлага

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 24-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт	4
4. Хүүхэд тээврийн үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага.....	4
5. Хүүхдийн автобусанд тавигдах техникийн шаардлага	5
6. Тэмдэг, тэмдэглэгээ.....	8
7. Тусгай дохио	9
8. Чиглэл, замнал, мэдээллийн стандарт	10
9. Жолоочийн хүлээх үүрэг	10
10. Зорчигч буюу хүүхдийн хүлээх үүрэг	13
11. Аюулгүй байдлын шаардлага	13
Хавсралт 1. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа.....	15
Хавсралт 2. Нийтийн тээврийн хэрэгслийг шалгах хуудас	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хүүхдийн автобусны харагдах байдал	5
Зураг 2. Суудлын байрлалын хэмжээ	6
Зураг 3. Суудлын хэмжээ	6
Зураг 4. Зорчигчийн хаалганы гишгүүр /жишээ/.....	7
Зураг 5. Зорчигчийн хаалганы бариул.....	7
Зураг 6. “Хүүхдийн автобус”-ны бичээсийг хийх загвар	8
Зураг 7. Тэргэнцэртэй хүүхэд бууж, суухад зориулсан өргөгч шат	8
Зураг 8. Автобусанд тэргэнцрийг түгжсэн байдал.....	8
Зураг 9. Дэлгэсэн байдал	9
Зураг 10. Эвхсэн байдал	9



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Зорчигч тээврийн үйлчилгээнд хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Зорчигч тээврийн үйлчилгээ бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1.UCS1601B:2022 “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.2.UCS1602B:2022 “Такси зогсоолд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.3.UCS1603B:2022 “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт


1.4.UCS1604B:2022 “Хүүхдийн автобусанд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.5.UCS1605B:2022 “Такси үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

2.Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1116100333

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 24
дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт



ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

UCS 1604B:2022 “ХҮҮХДИЙН АВТОБУСАНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартаар нийслэлийн нутаг дэвсгэрт хүүхдийг аюул осолгүй, ая тухтай тээвэрлэхэд тавигдах шаардлагыг тогтооно.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- MNS 4598:2020 “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага”;
- MNS 5012:2021 “Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага”;
- MNS ISO 3833:2010 “Авто тээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт”;
- MNS 6440:2014 “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага”;
- Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм;
- Авто тээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хүүхэд тээвэрлэх автобус (автобус) - үйлдвэрлэгчээс 22–оос дээш зорчигчийг суудлын тоогоор тээвэрлэхэд зориулан тоногдсон автобус;

Тээвэрлэгч - тээвэрлүүлэгч болон эрх бүхий бусад байгууллагатай хүүхэд тээвэрлэлтийг гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэн;

Тээвэрлүүлэгч - тээвэрлэгч байгууллагатай хүүхэд тээвэрлүүлэхээр байнгын тээвэрлэлтийн гэрээ байгуулсан боловсролын байгууллага;

Хүүхэд тээвэрлэлт - тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр хүүхэд тээвэрлэх автобусаар үйлчилгээний тогтоосон замнал, цагийн хуваарийн дагуу гүйцэтгэж буй тээвэрлэлт.

4. ХҮҮХЭД ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Хүүхэд тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь MNS 4598 : 2011 “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага”, “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандартын шаардлагыг бүрэн хангаж үйлчилгээ үзүүлнэ.

- 4.2. Үйлдвэрлэснээс хойш 12 жилээс дээш хугацаанд ашиглагдсан тээврийн хэрэгслийг Хүүхэд тээврийн үйлчилгээнд ашиглахыг хориглоно.
- 4.3. Техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан автобусаар үйлчилгээ үзүүлнэ.
- 4.4. Цэвэр, цэмцгэр, тав тухтай, аюулгүй зорчих боломжийг хангасан байна.
- 4.5. Автобусны техникийн хурдыг цагт 50 км-ээс хэтрүүлэхгүйгээр хөдөлгөөнд оролцоно.
- 4.6. Тээвэрлэлтийн явцад сурагчдад зөвлөмж, зааварчилгаа өгөх, хяналт тавих, хүүхдэд туслах үүрэгтэй насанд хүрсэн нэг хүн ажиллана.
- 4.7. Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл дотор замналын зураг болон бусад санамжуудыг зохих стандартын дагуу бичиж байрлуулсан байна.
- 4.8. Автобусаар зөвхөн хүүхэд тээвэрлэнэ.
- 4.9. Хөдөлгөөн эхлэхийн өмнө хүүхдэд зөв суух, бүс бүслэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг сахих зааварчилгааг өгнө.
- 4.10. Автобус бүрэн зогссоны дараа хүүхдүүдийг буулгаж, суулгаж, хаалгаа гүйцэд хаасны дараа хөдөлгөөнийг эхлүүлнэ.

5. ХҮҮХДИЙН АВТОБУСАНД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

- 5.1. Хүүхдийн автобус нь хүүхдийн ая тухтай, аюул осолгүй зорчих нөхцөл бүрдсэн, техникийн хувьд “Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага” MNS 4598:2011 стандарт, “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440 : 2014 стандартын үзүүлэлт, шаардлагыг бүрэн хангасан байна.



Зураг 1. Хүүхдийн автобусны харагдах байдал (Жишээ зураг)

- 5.2. Нийтийн тээврийн хэрэгслийн тоноглол нь MNS 4599:2003 “Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлт” стандартын шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.3. Зорчигчийн танхим


5.3.1. Зорчигчийн танхим нь эрүүл ахуй, ариун цэвэр, галын болон хөдөлгөөний аюулгүйн шаардлагыг бүрэн хангасан, дулаацуулга, агааржуулалт, салхижуулалт, сэрүүцүүлэх систем, цонх, нээлхий, гал унтраагуур, эмийн сан зэргээр тоноглогдсон байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- суудал нь автобусны явах чиглэлийн дагуу харж байрласан байна;
- автобус нь гар тээшний тавиуртай байна;
- автобусны зорчигчийн танхимын цонхны дээд талын гар тээшний тавиурын өргөн нь 300 мм-ээс, сул зайн өндөр нь 200 мм-ээс багагүй байна. Тавиур автобусны хана тал руу налуутай хийгдсэн байна. Налуугийн хэвтээ гадаргуутай харьцангуй хэмжсэн өнцөг нь 10° -аас багагүй байна;
- зорчигчийн танхимын хажуугийн цонх салхивчтай үед салхивчийн өндөр нь цонхны нийт өндрийн $1/3$ -ээс хэтрэхгүй байна. Салхивч нь цонхны дээд хэсэгт байрлана.


5.4. Зорчигчийн суудал

5.4.1. Хүүхдийн автобусны суудал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- суудлын түшлэгийн урд гадаргуугаас түүний өмнө байрласан суудлын түшлэгийн арын гадаргуу хүртэлх H зай 600 мм-ээс багагүй байна. (5.2-р зураг);
- суудлын тавцангийн өргөн F нь 320 мм-ээс багагүй байна (5.3-р зураг);
- суудлын тавцангийн урт K нь 350 мм-ээс багагүй байна (5.2-р зураг);
- хөл тавих шалны хэсгээс дээш сандлын тавцангийн дээд ирмэг хүртэлх өндөртэй 350 мм-ээс 400 мм байна. (5.3-р зураг);
- автобусны голын чөлөөт зай талын захын суудал нь тохойны түшлэг, бариултай байна. Тохойны түшлэг болон бариул нь сандлын тавцангаас дээш B өндөртэй (180 ± 20) мм байна. (5.2-р зураг);
- автобусанд хүүхдийг харгалзан явах 1-ээс доошгүй насанд хүрсэн хүнд зориулсан суудалтай байна. Энэ суудлыг автобус явж байх үед насанд хүрсэн зорчигч хүүхдүүдэд хяналт тавьж болохоор байршилд байрлуулсан байна.



Зураг 2. Суудлын байрлалын хэмжээ
(Жишээ зураг)



Зураг 3. Суудлын хэмжээ
(Жишээ зураг)

5.5. Зорчигчийн хаалга, гишгүүр

5.5.1. Хүүхэд тээвэрлэх автобус нь 2-оос илүүгүй хаалгатай байна.

5.5.2. Хүүхэд тээвэрлэх автобусны зорчигчийн хаалга нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- автобусны хамгийн доод гишгүүр нь замын гадаргуугаас дээш 250 мм-ээс илүүгүй өндөрт байна. Шаардлагатай тохиолдолд энэхүү өндрийг хангахын тулд эвхэгддэг шат (гишгүүр) тавих бөгөөд шалыг доош буулгадаг эсхүл хазайлгадаг систем хэрэглэнэ;
- шатны гишгүүрүүдийн өндөр 200 мм-ээс илүүгүй байна;
- гишгүүрийн өргөн 200 мм-ээс багагүй байна.



Зураг 4. Зорчигчийн хаалганы гишгүүр (Жишээ зураг)

5.6. Зорчигчийн хаалганы бариул

Хүүхдийн автобусны бариул нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.6.1. Хүүхдийн автобусны бариул нь дараах шаардлагыг хангасан байна;

5.6.2. Зорчигчийн хаалга нь хоёр хажуу талдаа барих бариулаар тоноглогдсон байна;

5.6.3. Бариул нь хүүхэд хаалганы дэргэд эсхүл аль нэг гишгүүр дээр зогсоод түүнээс барих боломжтой байхаар байрласан байна;

5.6.4. Хүүхэд автобусанд орох, буухад барих бариул нь хаалганы ойролцоо эхний гишгүүрийн гадна ирмэгээс (хэвтээ чиглэлд) 300 мм-ээс хэтрэхгүй зайд байрлана.




Зураг 5. Зорчигчийн хаалганы бариул (Жишээ зураг)

5.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан нэмэлт тоноглол

- 5.7.1. Тэргэнцэртэй хүүхэд сууж, буухад зориулагдсан шаттай байна /гишгүүргүй, өргөгчтэй шаттай/;
- 5.7.2. Автобусанд тэргэнцэртэй хүүхдэд зориулсан суудалтай байна /тэргэнцэр түгжигчтэй/;
- 5.7.3. Автобусанд тэргэнцэртэй хүүхэд явахад саад болохгүй зай талбайтай байна;
- 5.7.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зорчиход зориулсан бариулуудтай байна;
- 5.7.5. Зориулалтын цонх, агааржуулалтын системтэй байна /цонх хагас онгойдог хөдөлгөөнгүй, хязгаарлагчтай/;
- 5.7.6. Харааны болон сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан бууж, суух, автобус хөдөлж, зогсохыг зарлах тусгай хэрэгсэлтэй байна.



Зураг 6. Тэргэнцэртэй хүүхэд бууж, суухад зориулсан өргөгч шат (Жишээ зураг)



Зураг 7. Автобусанд тэргэнцрийг түгжсэн байдал (Жишээ зураг)

6. ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ

- 6.1. Автобусны хоёр хажуу талд дармал том үсгээр “ХҮҮХДИЙН АВТОБУС” гэсэн бичээс бүхий туузыг нийтэд тод харагдахаар байрлуулна. Зураг 6.1-д үзүүлэв.



Зураг 8. “Хүүхдийн автобус”-ны бичээсийг хийх загвар (Жишээ)

- 6.2. Бичээс нь дараах шаардлагын дагуу хийгдсэн байна. Үүнд:

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт	
1	Туузын хэмжээ	Урт 2200 мм, Өргөн 180 мм	-
2	Үсгийн хэмжээ	Өндөр 100 мм, Өргөн 50 мм	-
3	Дэвсгэр өнгө	Шар	С-6, М-0, Ү-96, К-0
4	Үсгийн өнгө	Хөх	С-93, М-75, Ү-38, К-27

- 6.2.1. Бичээсний ойр тэдгээрийн өндрийн $\frac{1}{2}$ - ээс багагүй зайд ямар нэг тэмдэг, тэмдэглэгээ, бичээсгүй байна;
- 6.2.2. Автобусны их биеийн будагтай гадаргуу дээр, хажуугийн салхины шилний доод хэсэгт газраас 1200 мм-ээс 1500 мм-т байрлана;
- 6.2.3. Бичээсийг “Монгол цагаан толгой дармал үсэг” MNS 4333:1996 стандартын дагуу /Arial font/ хийсэн байна.
- 6.3. Замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу улаан хүрээтэй, шар өнгийн дэвсгэр бүхий дөрвөлжин (нэг талын урт нь 250 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь нэг талын хэмжээний $\frac{1}{10}$ -тэй тэнцүү) дотор хар өнгөөр 1.18 тэмдгийн доторх дүрсийг зурсан “Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл” гэсэн таних тэмдгийг автобусны урд болон хойд талд байрлуулна.



(Жишээ зураг)

7. ТУСГАЙ ДОХИО

- 7.1. Зорчигч буулгаж, суулгах үеийн аюулгүй байдлыг хангах үүднээс шар өнгийн тусгай гэрлэн дохиогоор тоноглоно.
- 7.2. Гэрлэн дохиог автобусны зүүн урд болон хойд хэсэгт байрлуулах ба бусад хөдөлгөөнд оролцогсдод харагдахуйц зай хэмжээнд байрлуулна.
- 7.3. Автобусны өндөр 3000 мм-ээс илүү тохиолдолд тусгай гэрлэн дохиог орой дээр байрлуулахыг хориглоно.
- 7.4. Автобусны зүүн гар талд, урд хэсгээс 1800 мм-ээс 2000 мм зайд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 3.5-д заасан “ЗОГСОХГҮЙ ЯВАХ ХОРИОТОЙ” тэмдгийг эвхэгддэг байдлаар байрлуулсан байна.
- 7.5. Зорчигч бууж, суух үед жолооч тухайн тэмдгийг зорчих хэсэг рүү харуулан дэлгэх ба хөдөлгөөнд оролцох үедээ хураасан байдалд байрлуулна.
- 7.6. Тэмдэг нь хөдөлгөөний үед савахгүй, дэлгэхэд хүндрэлгүй, түгжигддэг байна.
- 7.7. Тэмдэг нь автомат ажиллагаатай байж болох ба техникийн гэмтлээс шалтгаалахгүй гараар нээгдэж хаагддаг, түгжигддэг байж болно.



(Жишээ зураг)

“Зогсохгүй явах хориотой” тэмдгийн харагдах байдал



Зураг 9. Дэлгэсэн байдал
(Жишээ зураг)



Зураг 10. Эвхсэн байдал
(Жишээ зураг)

8. ЧИГЛЭЛ, ЗАМНАЛ, МЭДЭЭЛЛИЙН СТАНДАРТ

- 8.1. Хүүхдийн автобусны чиглэл, замналын мэдээлэл, санамж, анхааруулгыг эрх бүхий байгууллагаас баталсан загварын дагуу бэлтгэн хүүхдүүдэд харагдахаар автобусанд байрлуулна.

9. ЖОЛООЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 9.1. Ажилд гарахдаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгуулж, зохих бүртгэлд тэмдэглүүлэх.
- 9.2. Тогтсон зогсоол, хуваарьт заасан цаг, минутыг баримталж ажиллах.
- 9.3. Хөдөлгөөнд оролцохын өмнө болон замд явахдаа автобусны техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.
- 9.4. Хөдөлгөөнд оролцох үед техникийн эвдрэл саатал гарсан тохиолдолд нэн даруй холбогдох байгууллагад мэдэгдэж, дараагийн автобус иртэл хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.
- 9.5. Жолооч ажил амралтын дэглэмийг мөрдөж ажиллана. /тасралтгүй ажиллах хугацаа 4 цаг, хоногт ажиллах хугацаа 8 цагаас хэтрэхгүй байх/.
- 9.6. Хүүхэд тээвэрлэх автобусны жолооч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 9.6.1. 25 нас хүрсэн;
- 9.6.2. Тухай ангиллын тээврийн хэрэгсэл жолоодсон 5-аас дээш жилийн туршлагатай байх;
- 9.6.3. Эрүүл мэндийн хувьд тогтоосон шаардлагад тэнцсэн эрүүл байх;
- 9.6.4. Монгол хэлээр чөлөөтэй ярих, унших, бичих чадвартай байх;
- 9.6.5. Гадаад байдал, хувцаслалт, биеэ авч явах байдлын хувьд зохистой, муу зуршилгүй байх;
- 9.6.6. Хүүхэд тээвэрлэх үед жолооч дараах зүйл хийхийг хориглоно. Үүнд:
- автобусанд суудлын тооноос илүү хүүхэд тээвэрлэх;
 - зорчигчийн танхимд хүүхэд байх үед автобусыг эзгүй орхих;
 - автобусыг хүүхэд суулгах, буулгах газраас өөр газар зогсоох;
 - хөдөлгөөний үед огцом тоормослох;
 - тамхи татах;
 - хөдөлгөөнд оролцох үедээ гар утсаар ярих;
 - хөдөлгөөнд оролцох үед техникийн эвдрэл саатал гарсан нэн даруй холбогдох байгууллагад мэдэгдэж, дараагийн автобус иртэл хүүхдийг автобуснаас буулгахгүй байх;
 - согтууруулах ундаа хэрэглэсэн, биеийн байдал, эрүүл мэнд муудсан, хэт ядарсан үед тээврийн хэрэгслийг жолоодохгүй байх.
- 9.6.7. Жолооч ажилд гарахын өмнө тээврийн хэрэгслийн тоормосны систем, гэрэл дохио, хаалга, толь, дугуйг хийн даралтыг шалгасны дараа шалгах эрх бүхий ажилтанд шалгуулж шугам замд гарах.
- 9.7. Хүүхдийн автобусны жолооч нь өвлийн болон зуны дүрэмт хувцастай байна.

9.7.1. Өвлийн дүрэмт хувцсанд - цагаан цэнхэр өнгийн захтай цамц (сорочикон болон поло цамц), хар бараан өнгийн өмд, хөх өнгийн хүрэм, цагаан бээлий, малгайтай байна.

№	Дүрэмт хувцас	Зураг	Өнгө
1	Захтай цамц	 <p>(Жишээ зураг)</p>	Цагаан
			Цайвар цэнхэр
2	Өмд	 <p>(Жишээ зураг)</p>	Хар хөх
			Хар
3	Хүрэм	 <p>(Жишээ зураг)</p>	Хар хөх
4	Бээлий	 <p>(Жишээ зураг)</p>	Цагаан
5	Малгай	 <p>(Жишээ зураг)</p>	Хар
			Хар хөх

9.7.2. Зуны дүрэмт хувцсанд – цагаан, цайвар цэнхэр өнгийн захтай цамц (сорочикон болон поло цамц), хар бараан өнгийн өмд, цайвар өнгийн хүрэм эсхүл хантааз, цагаан бээлий, малгайтай байна.

№	Дүрэмт хувцас	Зураг	Өнгө
1	Захтай цамц	 <p>(Жишээ зураг)</p>	Цагаан
			Цайвар цэнхэр
2	Өмд	 <p>(Жишээ зураг)</p>	Хар
			Хар хөх
3	Хүрэм	 <p>(Жишээ зураг)</p>	Цайвар ногоон
			Цайвар саарал
4	Хантааз	 <p>(Жишээ зураг)</p>	Цайвар ногоон
			Цайвар цэнхэр
5	Бээлий	 <p>(Жишээ зураг)</p>	Цагаан
6	Малгай	 <p>(Жишээ зураг)</p>	Хар
			Хар хөх

10. ЗОРЧИГЧ БУЮУ ХҮҮХДИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 10.1. Автобус ирэхээс өмнө тогтоосон зогсоол дээр ирсэн байна.
- 10.2. Автобусанд бууж, суухдаа дарааллыг баримтална.
- 10.3. Хүүхэд нь жолооч болон зохион байгуулагчийн зааврыг /зорчигчийн аюулгүй байдлын дүрэм, санамж/ чанд мөрдөнө.
- 10.4. Автобусанд орж, гар тээшээ зориулалтын газар байрлуулж, суудалдаа сууж хамгаалах бүсээ зүүнэ.
- 10.5. Автобусны эд зүйл, тоноглолд хайр гамтай хандана.
- 10.6. Хогоо зориулалтын саванд хийнэ.

11. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГА

- 11.1. Хүүхдийн автобусны жолооч нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн дагуу аюулгүй байдлыг хангаж хөдөлгөөнд оролцоно.
- 11.2. Хүүхдийн автобусны жолооч нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана (Хавсралт 1).
- 11.3. Жолоочийн ажлын байр нь зорчигч автобусанд суух, буух явц болон тээвэрлэлтийн үед үйлчилгээний танхимыг хянах боломжтой, шаардлагатай тоноглол хэрэгсэлтэй байна.
- 11.4. Жолоочийн ажлын байр нь түүнийг зорчигчийн танхимаас тусгаарлах ямар нэгэн хаалтгүй байна.
- 11.5. Автобусны шал, гишгүүрийг резин материалаар бүрсэн, гулгаж халтирахаас сэргийлсэн байна.
- 11.6. Жолоочийн ажлын байр нь зориулалтын гадна болон дотор чанга яригч болон бусад мэдээллийн хэрэгслээр тоноглогдсон байна.
- 11.7. Автобус нь ухрах хөдөлгөөн хийх үед дуут дохиог автоматаар өгөх төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
- 11.8. Монгол улсын Замын хөдөлгөөний дүрмийн дагуу автобус нь гадна талдаа гэрэл ойлгууртай байна.
- 11.9. Галын хор, эмийн сан, бусад аюулгүй байдлын хэрэгслээр тоноглогдсон байна.
- 11.10. Автобусанд хүүхдийг харгалзан явах 1-ээс доошгүй насанд хүрсэн хүнд зориулсан суудалтай байна.
- 11.11. Автобус нь дараах аюулгүй байдлыг хангах иж бүрдэлтэй байна. Үүнд:

№	Багаж хэрэгсэл	Шаардлага
1	 <p>(Жишээ зураг)</p>	Ослын зогсолтын тэмдэгтэй байх.
2	 <p>(Жишээ зураг)</p>	Ослын гарцын шилийг хагалах алхыг зохих шаардлагын дагуу нүдэнд ил харагдах газар, санамж мэдээллийн хамт байрлуулах
3	 <p>(Жишээ зураг)</p>	Дугуйны 2-оос доошгүй ивүүртэй байх
4	 <p>(Жишээ зураг)</p>	Зохих шаардлагыг хангасан гал унтраагууртай байх
5	 <p>(Жишээ зураг)</p>	Зохих шаардлагыг хангасан эмийн сантай байх

ХАВСРАЛТ 1.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Тээврийн хэрэгслийн техникийн ажиллагааг шалгах үедээ гаднын хүн оролцуулахгүй байх тээврийн хэрэгслийг байрнаас нь хөдөлгөхдөө орчны аюулгүй байдлыг сайтар нягталсны даргаа хөдөлгөөнд оролцох, ухрах үйлдэл хийхдээ арын саад байгаа эсэхийг сайтар нягтлаад дуут дохио өгч ухрах.
2. Жолооч замын хөдөлгөөний дүрмийг чанд биелүүлж урд болон хажууд яваа тээврийн хэрэгслийг мөргөхгүй, шүргэхгүй байх зай барьж явах.
3. Автобусны зогсоолд зогсохдоо тээврийн хэрэгслийн бүрэн зогссоны дараа хаалгаа нээж, зорчигчид бүрэн сууж байраа эзэлсний дараа хаалгаа хааж хөдөлгөөний эхлэх.
4. Төмөр замын гарам нэвтрэх замын хөдөлгөөний дүрмийг чанд мөрдөх.
5. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед нийтийн тээврийн үйлчилгээний ажилтан жолоочтой ярих, анхаарлыг сарниулах, жолоочид нөлөөлөх байдал үүсгэж явахыг хориглоно.
6. Хөдөлгөөн дунд цэвэрлэгээ хийхийг хориглоно.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ШАЛГАХ ХУУДАС

20.. оны ... сар... өдөр.... цаг ... минут

Тээврийн хэрэгслийн загвар, марк....., Улсын дугаар.....

Жолоочийн овог, нэр.....

Шалгах асуулт		Тийм	Үгүй
Нийтлэг шаардлага	Хурд хэмжүүр, дуут дохио бүрэн ажиллагаатай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хийн системийн ажиллагаа хэвийн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Дугуйн хийн даралт, хээний гүн стандартад заасан хэмжээнээс багагүй	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Шил алчуур, цан үлээгүүр хэвийн ажиллагаатай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хамгаалах бүс байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Автобусны гадна дотор талын болон оврын гэрэлтүүлэг стандартын шаардлага хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Маршрут заах, таних тэмдгийн гэрэлтүүлэг, арын цацруулагч бүрэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Заал болон хаалганы гэрэлтүүлэг бүрэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Эмийн сан, гал унтраагуур, ослын зогсолтын тэмдэг байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Салхины шил цуурсан зөрчилгүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хяналтын камер болон ледийн ажиллагаа хэвийн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Жолоочийн бүхээгний салхины хажуугийн ба арын шил бүрэн бүтэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Хаалга, гишгүүр бүхээгний нугасан холбоосны бэхэлгээ, түгжээ найдвартай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Жолоочийн суудал гэмтэлгүй, бүрэн бүтэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
Хөдөлгүүр, хүч дамжуулах анги	Хөдөлгүүр, хурдны хайрцаг, ерөнхий дамжуулагаас тос, хөргөх системээс шингэн гоожсон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Дискэн холбоо /авцуулах/ салахгүй буюу хий эргэхгүй байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Сэнсний оосрын элэгдэл, тохиргоо, гэмтэлтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Яндан болон дуу намсгуур хэвийн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Тоормосны систем	Дөрөөний сул ба бүрэн явалт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Тоормосны шингэн болон хий дамжуулах хоолой, гуурсны битүүмж хэвийн эсэх болон хийн системийн тундас авсан байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Зогсоолын тоормос хэвийн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Жолооны механизм	Жолооны хүрдний сул явалт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Жолооны хүрдийг эргүүлэх хүч	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Жолооны удирдлагын дамжуулга, татуурга, гар нугасан холбоос, эргэх нударганы сул явалт	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Явах анги	Нум/хийн нум/ пүршний байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Амортизаторын хэвийн байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Дугуй, булны бэхэлгээний байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Цахилгаан хэрэгсэл	Аккумуляторын / клем/ шон, болон бусад цахилгаан утасны холболт, бүрээс нь хэвийн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Хүүхэд тээвэрлэх үйлчилгээний талаар	Дотор цэвэрлэгээ хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Гадна цэвэрлэгээ хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Зорчигчийн бариул, суудлын бэхэлгээ, бүрээс хэвийн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Улсын дугаарын харагдах байдал хэвийн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Смарт цахим төхөөрөмж болон зогсоол зарлан, мэдээлэх хэрэгсэл ажиллаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Дулаацуулга, агааржуулалтын систем, гэрэлтүүлэг, салхижуулалтын систем бүрэн ажиллагаатай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Сандал, бариул эвдрэл гэмтэлгүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Заалны санамж бүрэн бүтэн, шаардлагад нийцэхээр байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Тусгай зориулалтын суудалтай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Тэргэнцэртэй зорчигчидод зориулсан тавцан ажиллагаа хэвийн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Тэргэнцэртэй зорчигчидод зориулсан орон зайг зорчих танхимд гаргаж өгсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Жолоочид тавих шаардлага	ХАБЭА-н зааварчилгаа авсан байх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Жолоочийн хувийн бэлтгэл хангагдсан эсэх жолооны үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, замын хуудас, мэргэшсэн жолоочийн үнэмлэх, ажлын хувцас, нэрийн хуудас бүрэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Байгалийн шахсан хий болон /CNG/, цахилгаан тэжээлт автобусны жолооч нь тусгайлан ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байна.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Жолоочийн биеийн байдал, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Цахилгаан болон шахсан /CNG/ хийн тэжээлт тээврийн хэрэгсэл	Шахсан хийн тээврийн хэрэгслийн тэжээлийн системийн битүүмж болон даралтад савны аюулгүй байдал хэвийн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
	Цахилгаан автобусны техникийн байдлыг шалгаж жолоочид техникийн болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн байна.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ТАЙЛБАР: Шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа бол тийм баганд тэмдэглэгээ хийнэ. Хангахгүй байгаа бол үгүй баганд тэмдэглэгээ хийнэ.

Шугамд гарахын өмнө тээврийн хэрэгсэлд техникийн ерөнхий үзлэг хийж үйлчилгээнд гарах ба шугамаас буухдаа тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг шалгах механикчаар заавал шалгуулна.

Техникийн хяналт хийж зөвшөөрсөн

Шалгах механик...../...../

Жолооч...../...../



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Наадамчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар